

**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-16

1. Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын нэгжийн үйл ажиллагаатай танилцах, салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл сонсох 3-16

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны
3 дугаар сарын 31-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны дарга Н.Батсүмбэрэл ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 6 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 57 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ш.Бямбасүрэн, Э.Одбаяр.

Нэг.Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын нэгжийн үйл ажиллагаатай танилцах, салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга В.Батчимэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Удирдах зөвлөлийн дарга О.Мөнхнасан, мөн холбооны Дэд ерөнхийлөгч Э.Тэнгисболд, гүйцэтгэх захирал М.Нарангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын нэгжийн үйл ажиллагаа, салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаарх мэдээллийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга В.Батчимэг танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, М.Энхцэцэг, Г.Лувсанжамц, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга В.Батчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын нэгжийн үйл ажиллагаа, салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаарх Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 49 минут үргэлжилж, 6 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 46 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 3 дугаар сарын 31-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
15 цаг 57 минут.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Батсүмбэрэл: Улсын Их Хурлын Даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо өнөөдөр хуралдаж байна. Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны гишүүн Батболд, Батсүмбэрэл, Лувсанжамц, Энхцэцэг нар ирж, дэд хорооны ирц 66,7 хувьтай байна. Иймд хуралдаан ирц бүрдсэн, хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын нэгжийн үйл ажиллагаатай танилцах, салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл сонсоно. Мэдээллийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга Батчимэг танилцуулна. Таныг урьж байна. Индрийн микрофон өгье.

В.Батчимэг: Эрхэм хүндэт Улсын Их Хурлын дэд хороодын гишүүд ээ,

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон тодорхойлсон. Монгол Улсын Засгийн газраас аялал жуулчлалын салбарт онцгой анхаарал хандуулан аялал жуулчлалын салбарт шинэтгэлийг эхлүүлж, бодлого, хууль, эрх зүйн бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтэц хөгжүүлэлт, олон улсын сурталчилгаа зэрэг бүх түвшинд төр, хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллага хамтдаа хүчин чармайлт гарган ажиллаж байна. Үүний үр дүнд Монгол Улс 2025 онд 847 мянга гаруй жуулчин хүлээн авч, экспортын орлого 728 сая ам.долларт хүрч, дотоодын жуулчдын зарцуулалт 2,6 их наяд төгрөгт хүрсэн ба нийт аялал жуулчлалын салбарт эдийн засгийн хэмжээ 5,2 их наяд төгрөг буюу 1,4 тэрбум ам.долларт хүрсэн нь аялал жуулчлал манай улсын эдийн засгийн чухал салбар болохыг бататгаж байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэргэдэх Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын тайланд жуулчдын тоогоор дэлхийн хамгийн өндөр өсөлттэй байгаа 20 орны жагсаалтад 15 дугаар байранд эрэмбэлэгдэж, бидний хүчин чармайлтын бодит үр дүн гарсан байна.

Аялал жуулчлалын салбарт хууль, эрх зүйн хувьд Аялал жуулчлалын тухай хууль 2002 онд батлагдсан байсан хууль маань 2023 онд шинэчлэн батлагдсан. Улсын Их Хурлын тогтоол 1, ЗГ /Засгийн газар/-ын 95 тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт хууль, эрх зүйн хэрэгжилт 2025 оны байдлаар 69,1 хувийн хэрэгжилттэй байна. Хэрэгжээгүй 4 заалтын тухайд гэвэл 2025 он гараад 2 асуудлыг батлуулсан ба үлдсэн 2 асуудлыг батлуулах шатандаа явж байна. Аялал жуулчлалын тухай хуулийг даган гарах 7 журам батлуулах байсны 6 журмыг батлуулсан ба одоо 1 журам буюу Даатгалын журам үлдсэн. Аялал жуулчлалын дунд хугацааны хөгжлийн бодлого маань Бүсчилсэн хөгжлийн бодлого баримт бичиг тусгагдсан 6 бүсийн төлөвлөлт, ЗГ-ын үйл ажиллагааны 4 улирлын аялал жуулчлал, аялал жуулчлалын стратегийн 14 зорилтыг хэрэгжүүлж ажиллаж байгаа.

Мөн өнгөрсөн хугацаанд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Улсын аялал жуулчлалын бүс батлагдсан. Монгол Улсын аялал жуулчлалын салбарт урт хугацаандаа кластераар хөгжих учиртай. Энэ нь бодлогын хүрээнд Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан улсын аялал жуулчлалын бүсийг 12 аймгийн 17 байршилд тодорхойлж, ЗГ-ын хуралдаанаар батлуулсан. Байгаль орчин, уур амьсгалын яам, Геодези, газар зүйн зохион байгуулалтын газар, Монгол Улсын Их сургуулийн Хот, бүс нутгийн хөгжлийн судалгааны хүрээлэнтэй хамтран салбарын мэргэжилтнүүд, судлаачидтай хамтран олон улсын судалгаа, хүчин зүйл дээр үндэслэн Монгол Улсын урт хугацааны бодлого, ЗГ-ын мөрийн хөтөлбөртэй уялдуулан бүс, хилийн заагийг тогтоолоо. Улсын аялал жуулчлалын бүсийг тогтоосноор байгаль, түүх, соёлын өвийг хамгаалж, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхийн зэрэгцээ эдгээр чухал нөөцийг зөв зохистой эдийн засгийн эргэлтэд оруулах юм.

Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгохтой холбоотой журмыг шинэчлэн батлууллаа. Жуулчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хурдацтай хөгжиж буй зочлох үйлчилгээний салбарыг бид өмнө нь 2008 оны стандарт, 2009 оны журмаар зохицуулж байсан бол 474 шалгуурыг хангах байгууллагаас шаарддаг байсан. Харин энийг шинэчилж, олон улсын жишгийн дагуу боловсруулж, батлуулсан ба зэрэглэл олгох процесст нь төрийн оролцоог багасгаж, байгууллага сайн дурын үндсэн дээр зэрэглэл тогтоолгох нөхцөлийг бүрдүүллээ. Бид дэлхийн олон орны жуулчдад үйлчилгээ үзүүлэхдээ олон улсын үйлчилгээний жишиг стандарттай нийцүүлэн аялал жуулчлалаа хөгжүүлэх нь зүйтэй юм. Мөн 4 улирлын аялал жуулчлал, манай орны жуулчдын 44 хувь нь зуны сард 3 сард хүрэлцэн ирдэг билээ.

Аялал жуулчлалын салбарт олон оролцогч талуудтай уулзалт хийхэд салбарын улирлын хамаарлыг бууруулах, бусад улирлын жуулчдын тоог, бусад улиралд жуулчдын тоог нэмэгдүүлэх хүсэлтийг тогтмол хуваалцдаг. Энэ зорилтын хүрээнд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг ЗГ-ын хуралдаанаар батлуулж, хэрэгжүүлж байна. Нийт 5 бүлэг 30 арга хэмжээг төлөвлөсөн, хэрэгжүүлж байна. “Цайны зам” автомашинтай аяллын нээлтийг хийлээ. Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард улс, Оросын Холбооны улсын аялал жуулчлалын сайд нарын 9 дүгээр хуралдаан 2025 оны 11 сард Дархан-Уул аймагт амжилттай зохион байгуулагдсан. Тус хуралдаан Цайны замын аяллыг хөгжүүлэх хүрээнд хөрш орнуудтай хилийн залгаа аймгийн, хил хил залгаа аймгийн төлөөлөл, аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчид тус орнуудтай хамтран ажилладаг аж ахуйн нэгжүүдийн гаргасан саналуудын талаар хэлэлцэж, арга хэмжээний үеэр 3 орны хамтын ажиллагааг бодит үр дүнтэй ажил болгохоор талууд Цайны зам авто аяллыг албан ёсоор нээж хамтран ажиллах бичигт гарын үсэг зурсан.

Travel платформ хөгжүүлэхэд бэлэн боллоо. Дэлхий даяар жуулчдын 60 хувь нь аяллаа онлайн орчинд захиалж, 94 хувь нь аяллын үеэр гар утсаа идэвхтэй ашигладаг. Манай орны хувьд шинэ, өдөр тутам хэрэглээтэй жуулчдын хувьд төдийлөн ээлтэй орны тоонд багтдаггүй. Дэлхийн Ухаалаг засаг 2, Дэлхийн банкны Ухаалаг засаг 2 төслийн хүрээнд travel платформ цогц систем хийгдэхээр 2023 онд батлагдсан. Гэвч энэхүү платформын мэргэжлийн болон техникийн шаардлагыг тодорхойлох ажил маань 2 жил хагас гацсан байсныг эрчимжүүлэн батлууллаа. Төслийн дагуу 2027 оны 3 сараас аялал жуулчлалын салбарын нэгдсэн платформ урьдчилсан байдлаар ашиглалтад орох юм.

Аялал жуулчлалын сургалтын төв бий болголоо. Салбарын хүний нөөцийн хэрэгцээ өндөр энэ цаг үед Монгол Улс Бүгд Найрамдах Солонгос Улсын ЗГ хоорондын хамтын ажиллагааны хүрээнд аялал жуулчлалын сургалтын төвийн барилгыг хүлээн аваад байна. Цаашид сургалтын төвийн барилгыг мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага буюу бидний хэлж заншсанаар МСҮТ-г албан ёсоор байгуулах бэлтгэл ажил хангагдаж байна.

Мөн шууд нислэгтэй газрын тоо нэмэгдэв. Монголд зочлон ирж буй жуулчдын 52 хувь нь агаарын тээврээр хүрэлцэн ирдэг ба тус салбар нь манай аялал жуулчлалын хөгжилд шууд нөлөөллийг үзүүлдэг билээ. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд агаарын тээврийн салбар амжилттай ажиллаж, Шанхай, Сингапурын чиглэлд үндэсний агаарын тээвэрлэгч компани тогтмол нислэг эхлэн АНУ United airlines, БНХАУ-ын Spring Airlines компаниуд манай оронд нислэг эхлүүлээ. 2025 онд агаарын тээврийн салбар 2,4 сая зорчигч тээвэрлэсэн ба өмнөх 2025 онтой харьцуулбал 14 хувийн өсөлттэй байна. Хөвсгөл аймагт олон улсын шууд нислэг хүлээн авлаа. 2025 оны 7 сард БНСУ-ын Чонжү хотыг Хөвсгөл аймгийн Мөрөн хот руу шууд нислэг үйлдэх анхны нислэгүүдийг хүлээн авлаа. Зөвхөн Улаанбаатар хотоор дамжин ирдэг байсан жуулчдын хувьд өөрийн аяллыг хүссэн газартаа шууд нислэгээр очих боломжийг ийнхүү бүрдүүлсэн нь манай орны аялал жуулчлалын салбарт төдийгүй зам, тээврийн салбарт чухал алхам боллоо.

Аялал жуулчлалын салбарын хөнгөлөлттэй зээлийг энэ сараас олгож эхэлнэ. Монгол Улсын ЗГ-аас аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг дэмжихэд чиглэсэн 6 жилийн хугацаатай 6 хувийн зээлийг гаргахаар шийдвэрлэсэн. Энэхүү хөнгөлөлттэй зээлийн нөхцөл гэрээг талууд харилцан тохиролцсон ба зээл олгох ажлыг эхлүүлж байна. Аялал жуулчлалын салбар бол хамтын ажиллагааны салбар. Зам, тээвэр, нисэх онгоц, нисэх буудал, авто зам, тээврийн хэрэгсэл, хил гааль, зоог, идээ ундаа, байгаль, түүх, соёл, хөтөч, түр оператор, аялал жуулчлалын менежер, агентууд, зочид буудал, жуулчны бааз, үзвэр үйлчилгээ гэх мэтчилэн олон оролцогч талуудын итгэлтэй, бат бөх хамтын ажиллагааны үр дүнд аялал жуулчлалын салбар амжилттай ажилладаг билээ. Өнө эртний түүхтэй өв соёл уламжлалтай Монгол орон маань нүүдэлчин соёл, иргэншил, өргөн уудам тал нутаг, унаган байгаль, өвөрмөц соёлоороо дэлхий дахины анхаарлыг татаж байна. Энэхүү онцгой нөөц, нөхцөл байдлыг бодит ажил болгож, уул уурхайгаас хамааралтай эдийн засгаа солонгоруулах боломж бидний өмнө ирээд байгаа билээ. Шинэ цагийн жуулчид байгаль орчинд ээлтэй, үндэсний соёлын мөн чанарыг мэдрэхийг хүсэж, илүү амар амгалан байдал, гүн дурсамжийг үлдээх аяллыг эрэлхийлж байна. Энэ шинэ чиг хандлагад Монгол Улс бүрэн нийцэх нь онцгой боломжтой юм.

Иймд Монгол Улсын аялал жуулчлалын хөгжлийн стратеги дараах үндсэн зарчмуудад тулгуурлан хэрэгжиж байна. 1 дүгээрт, тогтвортой аялал жуулчлал. Байгаль орчин, соёлын өвийг хамгаалах, түүний үнэ цэнийг бодитой үнэлэн нэмэгдүүлэх, Монголын аялал жуулчлалын салбарын суурь зарчим байх ёстой. Одоогоор батлагдаад байгаа 17 улсын аялал жуулчлалын бүс болон шинээр батлагдах бүсүүдэд онцгой анхаарал хандуулан нэгдсэн төлөвлөлт, менежменттэй байгаль, өв соёл, орон нутаг, нутгийн иргэд, бизнес эрхлэгчид, жуулчдад ээлтэй, эдийн засгийн бодит үр өгөөжийг бий болгосон тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхийг зорих болно.

2 дугаарт, чанартай үйлчилгээ, мэргэжлийн хүний нөөцийг чадавхжуулах. Аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүний нөөцийг бэлтгэх зорилгоор “Зочломтгой Монгол хүн” цогц сургалтын хөтөлбөрийг

хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган эхэлж байна. Хөтөлбөрийн хүрээнд үйлчилгээний салбарын стандартыг олон улсын түвшинд хүргэхийг зорин Аялал жуулчлалын сургалтын төв мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн ажиллана.

3-д, 4 улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх. Улирлын хамаарлыг бууруулах зорилгоор 4 улирлын аяллын улс болох зорилтыг дэвшүүлэн өвөл, хавар, намар аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ. Жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээ, event арга хэмжээг бодлогоор дэмжин, гадаад сурталчилгааг.../минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофон нээе.

В.Батчимэг: Event арга хэмжээг бодлогоор дэмжин, гадаад сурталчилгааг улирлын хамаарлыг бууруулахад чиглэн ажиллаж байна.

4 дүгээрт, зам дагуух үйлчилгээ. Авто замын аялал жуулчлал, авто зам, аялал жуулчлалын бүсүүдийн дэд бүтцийг сайжруулах, жуулчдын ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэх бодлогыг шат дараалан хэрэгжүүлж байна. Нэн тэргүүнд зам дагуух үйлчилгээний цогцолборын тоог нэмэгдүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөөгүй цахилгаан автомашиныг цэнэглэх боломжоор хангах, стандартын дагуу тав тухтай ариун цэврийн байгууламж бүхий цогцолборуудыг байгуулахад хувийн хэвшилтэй хамтран ажиллана.

5 дугаарт, орон нутагт нислэг хүлээн авах. Хөвсгөл аймгийн Мөрөн нисэх буудлыг өргөтгөх ажлыг манай яамны зүгээс холбогдох санхүүжилтийг гарган ажиллахаар шийдвэрлэсэн. Мөн Өмнөговь аймгийн Гурвансайхан, Ховд аймагт Ховд нисэх буудлууд олон улсын нислэг хүлээн авахаар холбогдох талуудтай бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Жуулчдын тав тухтай аялах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор орон нутагт олон улсын шууд нислэг хүлээн авахад цаашид дэмжин ажиллах болно.

6 дугаарт, шинэ цагийн жуулчдад зориулсан дижитал аялал жуулчлалыг хөгжүүлэх. Жуулчдад Монголд зочлох, Монголд зочлон ирэхдээ ашиглах боломжтой цахим виз, онлайн төлбөр, үзвэр үйлчилгээ зорин очих газрын мэдээлэл, аудио хөтөч зэрэг дижитал шийдлүүдийг багтаасан аялал жуулчлалын application веб сайтыг Дэлхийн банкны Ухаалаг засаглал төслийн хүрээнд нэвтрүүлэхэд хамтран ажиллаж байна. Мөн Монгол Улсад аялахаар судалгаа хийж буй жуулчдад visit.mongolia.gov.mn сайтыг ашиглалтад оруулах ба жуулчид албан ёсны мэдээ мэдээлэл, холбогдох дүрэм журмуудыг уг веб сайтаас хүлээн авах юм.

7-д, жуулчдыг дайлах Монгол зоогийг хөгжүүлэх. Орчин цагийн жуулчдын аяллын нэг салшгүй хэсэг дурсамж болсон Монгол зоогийг хөгжүүлэхэд анхааран зочлох үйлчилгээний мэргэжлийн байгууллага, тогоочид, хүнс үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллаж байна. Жуулчдын амтлах мэдрэмж, онцлогтой нийцсэн хоолны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Монгол зоогийг хөгжүүлэх, нийлүүлэлтийн сувгийг бий болгох уялдаа холбоо бүхий цогц ажлыг хийж гүйцэтгэнэ.

8 дугаарт, Монголын аялал жуулчлалын брэнд. Монгол Улсыг дэлхийд нүүдэлчин соёл, адал явдалт онгон байгальд суурилсан онцгой аяллын чиглэл болгон таниулах маркетингийн Монголын их амар амгалан нэгдсэн бодлогыг хэрэгжүүлнэ. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам маань аялал

жуулчлалын салбарт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх ADB Азийн хөгжлийн банкны төслийг Хөвсгөл, Хэнтий аймгуудад хэрэгжүүлж байна. Мөн БНСУ-ын ЗГ олон улсын байгууллагуудын санхүүжилтээр сургалтын төвийг бий болгосон хүрээнд 2026-аас 2028 онуудыг дуустал салбарын хүний нөөцийг чадавхжуулах төслийг Койка олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлэх болсон. Япон улсын Жайка олон улсын байгууллагын Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Өмнөговь, Сэлэнгэ, Дархан, Төв аймгуудад 2026-аас 2028 онуудад хэрэгжүүлнэ.

Улсын аялал жуулчлалын бүсийн төлөвлөлтийг боловсруулах, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцөлийг бүрдүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн хог хаягдлыг бууруулах, байгальд ээлтэй аяллын соёлыг төлөвшүүлэх зорилгоор Америкийн Дэ Нэйче Консерванси (TNC) байгууллагатай хамтарч ажиллах санамж бичиг байгуулсан. Бид цаашид салбарын хүний нөөцийг чадавхжуулах хүрээнд олон улсын хөдөлмөрийн байгууллага ILO олон улсын байгууллагатай хамтран ажиллана. Мөн Дэлхийн банкттай Монгол Улсын аялал жуулчлалын портал хөгжүүлэх төслийг хөгжүүлэх зэргээр олон улсын байгууллагуудтай шат дараалан хамтран ажиллаж байна. Монгол Улсын аялал жуулчлалын хувьд улирлын хамаарлаас болоод 11 сараас 5 сар хүртэлх хугацаанд алдангийг багасгах зорилгоор өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 12 сард ЗГ-ын хуралдаанд танилцуулж, батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хүрээнд өвлийн улирлын хөнгөлөлттэй аяллын багцыг санал болгож, говийн бүсийн аймгуудад тэмээний event арга хэмжээнүүдийг зохион байгуулж, мөн өвлийн спортын төрлийн уралдаан тэмцээнүүдийг бодлогоор дэмжин зохион байгуулж, 2026 оны 3 сарын 29-ний байдлаар 139560 жуулчин ирсэн.

Жуулчдын тоог өмнөх 2025 онтой харьцуулбал 1 сар 48 хувийн өсөлттэй, 2 сар 33 хувийн өсөлттэй, 3 сард 35 хувийн өсөлттэй тус тус өсөлтийг үзүүлж байна. Зам дагуу түр буудаллах цэгийг 200-аас 250 км-т бий болгохоор 58 газрыг төлөвлөсөн боловч хэрэгжилт удаан байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын асуудлаас шалтгаалж байсныг 6 хувийн хүүтэй, 6 жилийн зээлийн төрөлд багтаан олгож, аж ахуйн нэгжүүдийг дэмжих замаар ариун цэврийн байгууламжийн асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна. Мөн байгалийн цогцолборт газруудад аялал жуулчлалын төлөлтийг хийх, отоглох цэг болон аялал жуулчлалын цогцолборыг шийдвэрлэх бодлого барьж ажиллаж байна. Жуулчин хүлээж авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ор хоногийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа тул 6 хувийн хүүтэй, 6 жилийн зээлийн асуудлыг энэ жилийн батлагдсан 250 тэрбум төгрөгийн зочид буудал, жуулчны бааз, аялал жуулчлалын цогцолборт хөрөнгө оруулалт хийхэд анхаарч төлөвлөсөн юм.

Бид цаашид хууль, эрх зүйн шинэчлэл бодлогын хувьд аялал жуулчлалыг хөгжүүлэх сан бий болгох, татварын орлогыг нэмэгдүүлэх, улмаар эгүүлэн салбарт зарцуулдаг байх, дэд бүтцийг хөгжүүлэх, аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, засварлах, тээвэрлэх, байршуулах хэрэгслийг болон жуулчны сонирхлыг татах бүтээн байгуулалтыг бий болгох, үзвэрүүдийг сайжруулах зэрэгт анхаарч ажиллана. Тогтвортой аялал жуулчлал, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, орон нутгийн иргэдэд ашиг тусаа өгөх аялал жуулчлалын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мөн аялал жуулчлалын зорин очих газруудад чиглэсэн агаарын тээврийн дэд бүтэц, нисэх онгоцны буудлууд олон улсын шаардлагыг хангахгүй байгааг сайжруулах, хилийн боомтуудын нэвтрэх урсгал удаан, хүчин чадал сул, зорин очих газруудад чиглэсэн авто замын дэд бүтцүүддээ сайжруулах шаардлагуудтай байна.

Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи бүхий өвлийн улиралд ажиллах жуулчны баазын тоо хүчин чадалд хангалтгүй байна. Жуулчдын сонирхлыг татах үндсэн онцлог бүхий бүтээн байгуулалт үзмэрүүдийг сайжруулах зэрэгт тус тус анхаарч ажиллахаар төлөвлөж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Танилцуулга хийсэн Батчимэг даргад баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын үүрэг гүйцэтгэгч Ундрэм, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын зөвлөх Золбадрал, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын дарга Батчимэг, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны дэд ерөнхийлөгч Тэнгисболд, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны удирдах зөвлөлийн дарга Мөнхнасан, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал Нарангэрэл, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Жаргалан нар оролцож байна.

Танилцуулгатай холбоотой асуулт, үг хэлэх гишүүд нэрээ өгье. Батболд гишүүнээр тасаллаа. Ундрэм гишүүн. Батболд гишүүн.

Р.Батболд: Сайдыг орж ирэхээс өмнө түрүүн яамныхантайгаа жоохон санал солилцлоо. Тэр санаануудаа дахиад энд яг хэлчихье гэж бодож байна. 1 дүгээрт, бид нар аялал жуулчлалыг бүсчилсэн хэлбэрээр юм уу, аль нэг хэсэгт ингээд аялал жуулчлалын салбар байгуулах гэж байгаа бол ямар бодлоготой явах юм бэ гэдгээ эхлээд сайн тодорхойлох хэрэгтэй болж байгаа байх. Тэрэлжийн жишээн дээр харвал бид ам болгонд 4-өөс 5 байдаг юм уу, эсхүл жалганы цаана л нэг ингээд л өөр, өөр жуулчны компаниуд байдаг юм уу ингээд бүгдээрээ кемп бариад явчихдаг. Энэ нь өөрөө нөгөө ашиг орлого орох байдаг юм уу, хүмүүсийн дутагдалтай болчихоод, тэгээд үнээ нэмэхээс өөр аргагүй болгочихдог. Ингээд дотоодын аялал жуулчлалаа өөрсдөө хаагаад байдаг нэг ийм байдал руу хүссэн, хүсээгүй түлхээд яваад байна л даа. Тэгэхээр энэ тал дээр бас нэг юм бодох хэрэгтэй болж байгаа байх.

2 дугаарт гэвэл тэр нөгөө гаднаас ирж байгаа жуулчдын аялал жуулчлалын бүсүүд байна шүү дээ. Жишээлбэл говь руу явж байсан нөгөө нисэх онгоцнууд чинь байхгүй болчихсон ганцхан МИАТ явдаг, 4 удаагийн нислэгтэй болчихсон гэж байгаа юм. Тэгээд энэ чинь нөгөө ачааллаа даахаа больчихоод байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр салбарын яамнаасаа хүсэлт гаргаад байдаг юм уу энэ өөр авиа компаниудыг нисгэх ийм талын бодлого хэрэгжүүлбэл ямар вэ гэж бодож байгаа юм.

Өөр чинь нөгөө нэг зээлтэй холбоотой асуудал дээр энэ дээр юу байгаа юу лимит байгаа юу, хязгаар бий юу гэдэг нэг зүйл? Өөр түрүүн чинь бас нэг юм юу ярьчихлаа. Тийм л байна даа, ер нь гол санаанууд гэвэл тийм. Би түрүүн ярьж байсан юмаа мартчихлаа. Тэгэхдээ манайхан толгойдоо хийгээд авчихсан байх гэж бодож байна.

Н.Батсүмбэрэл: Ундрэм сайдын микрофон.

Ч.Ундрэм: Батболд гишүүний асуултад хариулъя. Бид энэ аялал жуулчлалын 17 бүсийг 12 аймагт анх удаа тодорхойлсон. Өмнө нь ерөөсөө ийм бүсчилсэн бодлого бас яг хэдийгээр нөгөө Монгол Улсыг 6 бүсэд хуваагаад эдийн засгийн тэргүүлэх чиглэл, дэд чиглэлээр нь тодорхойлоод явж байсан боловч яг ийм аялал жуулчлалын бүсүүдийг тодорхойлсон зүйл байгаагүй. Тэгээд анх удаа ЗГ-аар

12 аймгийн 17 бүсийг тодорхойлоод, одоо энэ 17 бүсийнхээ аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг олон улсын байгууллагын санхүүгийн болон know how дэмжлэгтэйгээр төлөвлөгөөг боловсруулаад явж байгаа. Тэгэхээр яг энэ хамгийн түрүүнд энэ 17 бүсийн, 17 бүсээс бас энэ чинь зарим бүсийг нь түрүүлж сонгож аваад төлөвлөгөөг боловсруулж байгаа. Эдгээр бүсүүд дээр бид ажиллана.

Гэхдээ аялал жуулчлалын салбар маань маш олон бусад салбар, мөн бусад яамнаас хамааралтай байдаг. Жишээлбэл сая таны хэлсэн Зам, тээврийн яамнаас зайлшгүй хамааралтай байдаг. Мөн нөгөө талд Байгаль орчны яамнаас газар олгох зөвшөөрлийг нь замбараагүй олгох ч байдаг юм уу өнгөрсөн хугацаанд ийм болсон зүйлүүд байдаг. Тэгээд Зам, тээврийн яам маань аль болохоор илүү либерал тийм нисэх агаарын тээврийн бодлого баримтлах тусам манай салбарт илүү хэрэгтэй. Тэгээд хувийн хэвشلүүд өөрсдөө яг нөгөө зах зээлийнхээ зарчмаар маршрутаа тодорхойлоод нисээд явж байгаа. Бидний бодлого бол гадаадын нислэгийг ганцхан Улаанбаатараар бус хойд, урд, баруун, зүүн хэсэгт шууд гадаад нислэг авах бодлого баримтлаач гэдэг асуудлыг байнга тавьж байгаа. Тэгээд өнгөрсөн жил анх удаа Хөвсгөл рүү 2 удаагийн нислэг авч чадсан. Энэ жил нэлээн олон удаагийн нислэг авахаар төлөвлөж байна.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ гэхэд л Монгол Солонгосын парламентын бүлгийн даргын хувиар Чэжүгээс шууд Солонгос руу, Мөрөн рүү нислэг авах асуудлыг бас ингээд яриад нэлээн нааштай явж байгаа. Тэгээд Ховд, нөгөө талд Дорнод, Өмнөговь руу шууд гадаад нислэг авбал 5 өдрийн чөлөөтэй амралттай байгаа гэр бүл гэхэд шууд Улаанбаатарт ирээд, тэгээд Өмнөговь руу явах гэж бүтэн өдрийг нэг талдаа, 2 өдрийг ч юм уу алдах биш шууд очоод үзээд аялаад явах нь зүйтэй юм гэж бодож байгаа. Зээлийн хувьд зочид буудал, ресортууд 7 тэрбум хүртэл авах боломжтой нэг зочид буудал, ресортууд, бусад жижиг газруудыг манай газрын дарга нар ажлын хэсгээс та бүхэнд нэмж хэлнэ. Ерөнхийдөө бид аль болохоор олон чиглэлээр зээлээ өгөхийг хүссэн боловч Сангийн яам болон Монголбанкнаас зарим хязгаарлалтуудыг хийгээд, тэгээд маш цөөхөн төрлөөр зээлүүдээ өгч байгаа. Энэ зочид буудал, ресорт зам дагуух үйлчилгээний.../минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Үргэлжлүүлж хариулъя.

Н.Учрал: Энэ зээл бол Монгол Улсын түүхэнд бараг байгаагүй хувийн хэвشلээ дэмжиж байгаа 6 хувийн хүүтэй, 6 жилийн хугацаатай гэдгээрээ, тэгээд эхний жил нь үндсэн зээлээ эргэж төлөхгүйгээр авах боломжтой. Гэхдээ манайхаас бүх аялал жуулчлалын салбарт харьяалагддаг холбоодынхоо компанийн нэрсийг банкнуудад хүргүүлчихсэн. Банкнууд мэдээж өөрсдөө эрсдэлээ хүлээж байгаа учраас зээлийн хүсэлт өгсөн хүмүүсээ харж байгаад тэгээд тэндээсээ хамгийн бага эрсдэлтэй компаниудаа сонгож өгөхөөр байгаа. Тэгэхээр гол зээлийн шийдвэр гаргаж байгаа газрууд арилжааны банкнууд гэж үзэж болно. Нэмэлтээр ажлын хэсэг.

Н.Батсүмбэрэл: Батболд гишүүний микрофоныг нэмж тодруулъя.

Р.Батболд: Түрүүн хэлэх гээд байсан юмаа сая яг бүсийн гээд саначихлаа. Нөгөө Хэнтийн Дадалд хийгдэж байгаа хэдэн ажлууд байгаа шүү дээ нэг тийм, нөгөө тийм төсөл явж байгаа. Тэгээд тэр яг үргэлжилж байгаа юу, зогсчихсон байгаа юу гэдэг асуудал байгаа. Тэрийгээ нэг хурдан бариад, ашиглалтад оруулчихвал бас их хэрэгтэй байгаад байгаа юм. Нэг юм эхлүүлчхээд хаячихаар бас болдоггүй. Зам,

тээврийн яамтай ярьж байгаад засмал замыг нь цаашаа Дадал руу татах ч байдаг юм уу, эсхүл нэг тэр ажлыг бас юу болж байгаа юм бол? Тэр чинь хаанаас цааш байхгүй билээ, Баян, юу билээ, наад талын сум нь юу билээ? Батноров билүү? Батноров, Батширээт билүү? Тийм, Батширээт билүү тэндээс цааш байхгүй байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр тэр замын асуудлыг ч гэсэн яамны зүгээсээ санал болгоод, бидний аялал жуулчлалын гол төв маань тэнд байна. Тийм учраас тэрийг нэг ингэмээр байна гэдэг нэг саналаа солилцоод явбал зүгээр юм уу гэж бодоод байгаа юм. Тийм, баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофон. Батчимэг дарга.

В.Батчимэг: Баярлалаа. Батболд гишүүний асуултад хариулъя. Азийн хөгжлийн банкнаас Хөвсгөл аймаг болон Хэнтийд төсөл хэрэгжиж байгаа тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх. Хэнтийн цогцолбор одоогийн байдлаар 65 хувийн хэрэгжилттэй хэрэгжиж байгаа. Үргэлжлүүлээд бид ажлуудаа эрчимжүүлэх дээр анхаарч ажиллах болно.

Н.Батсүмбэрэл: Баярлалаа. Энхцэцэг гишүүний микрофон.

М.Энхцэцэг: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Аялал жуулчлалын салбарын талаарх танилцуулгыг хийсэн яамныхандаа баярлалаа. Надад ерөнхийдөө 2 асуулт байна л даа. Нэгдүгээрх нь, мэдээж тэр аялал жуулчлалын компаниудад 6 хувийн хүүтэй, 6 жилийн хугацаатай ийм маш их хөнгөрүүлсэн нөхцөлтэй зээлийг өгөхтэй холбоотой асуудлыг. Тэгэхээр мэдээж хар даа, мэдээж зээл авах гэж байгаа компаниудын тоо бол маш их байгаа тэр ойлгомжтой, тийм үү? Гэтэл зээлийн нөгөө үндсэн санхүүжилт маань мэдээж хязгаартай. Тэгэхээр энэ дээр мэдээж олон асуудал үүснэ. Ямар шаардлага хангаж байгаа компаниудад 1 дүгээрт өгөх вэ гэдэг асуудлыг яриач?

2 дугаарт болохоор сая Ундром сайд хэлж байх шиг байна. Ерөнхийдөө мэргэжлийн холбоодынхоо нэрсийг банкнуудад өгсөн гээд тэгж байна. Тэгэхээр энэ санхүүжилтийг мэргэжлийн холбоод авах гээд байгаа юм уу, эсвэл тэр яг аялал жуулчлалын компаниуд авах гээд байгаа юм уу? Ерөнхийдөө би ингэж анзаардаг, зүгээр мэргэжлийн холбоод гээд нэг ийм тамга халаасалчихсан нөхөр цаашаа компаниудыг төлөөлж байгаа ч юм шиг, үгүй ч юм шиг, гэхдээ тэр компаниудын нэрийг ашиглаад яваад байгаа юм шиг санагдаад байдаг. Тэгэхээр аль болох аялал жуулчлалын компаниуд дээрээ яг тэр эзнээ олсон байдлаар энэ санхүүжилтийг олгох нь зүйтэй юм болов уу гэж бодож байна бодож байна. Энэ дээр бас хариулаач?

2 дугаарт болохоор сая Ундром сайд хэлж байна л даа. Нөгөө арилжааны банкнууд маань энэ зээлийг хэнд өгөх юм гэдэг шаардлагыг хангаж байгаа нөхдүүдэд өгөөд явна гээд тэгж байна л даа. Тэгэхээр нөгөө нэг ипотекийн зээлтэй адилхан асуудал энэ дээр үүсэх юм биш үү? Бараг ипотекийн зээлийг чинь тэр арилжааны банкнууд цаашаа дамлаад би чамд зээл гаргаж өгнө энэ тэр гээд. Тэгэхээр энэ аялал жуулчлалын энэ 6 хувийн зээл дээр чинь яг тийм асуудал үүснэ. Тэгэхээр энийг үүсгэхгүй байх талаар яамнаас ямар хяналтыг хийж байгаа вэ гэж асуумаар байна.

2 дугаар асуудал болохоор Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийг байгуулна гэж байна. Тэгэхээр яг ямар чиглэлээр мэргэжлийн ажилтан бэлтгэх ийм сургалтын төв байгуулах гэж байгаа вэ? Дээрээс нь энэ юу чинь улсын тийм

мэргэжлийн сургалтын үйлдвэрлэлийн төв байгуулах гэж байгаа юм уу? Энийг хувийн хэвшил дээр түшиглэж байгуулж болохгүй юу? Ямар хэмжээний зардалтай мэргэжил сургалтын төв байгуулах гэж байгаа юм, тэр маань ямар хэмжээний ашиг орлоготой, зардалтай ингээд цаашаа яваад байх юм бэ? Цаашдаа ер нь аль болох л энэ асуудлыг хувийн хэвшлийнхэн хийгээд явбал мэдээж зохимжтой. Дээрээс нь мөн одоо байгаа энэ МСҮТ-үүдийг түшиглээд тэр шаардлагатай байгаа аялал жуулчлалын мэргэжилтнүүдээ ч юм уу бэлдээд явах тийм боломж нь хэр байдаг юм бэ гэсэн ийм 2 асуулт байгаа.

3 дахь асуулт нь болохоор манайх руу жишээ нь Архангай, Хөвсгөл ч гэдэг юм уу яг ийм аялал жуулчлалын тодорхой ийм ачаалалтай байдаг, хол байдаг аймгууд руу жижиг хэмжээний оврын ийм онгоцыг нисгэх асуудлыг зохион байгуулж болдоггүй юм болов уу? Энэ тал дээр ямар асуудлууд та нарт байдаг юм гээд ийм 3 асуултыг асууя.

Н.Батсүмбэрэл: Ундрам сайдын микрофоныг өгье.

Ч.Ундрам: Энхцэцэг гишүүний асуултад хариулъя. Зээлийн шаардлагын хувьд яамнаас шаардлагуудыг нэлээн багасгасан, заавал аялал жуулчлалын салбарын компани байх ёстой, Монгол компани байх ёстой, тэгээд яг аялал жуулчлалын мэргэжлийн 2-оос багагүй хүн ажилладаг байх ёстой гэсэн ийм л шаардлагуудыг тавьж байгаа ерөнхийдөө. Тэгээд банк нөгөө яг зээлдэгчийн зээлдэгчид тавьдаг шаардлагуудаа тавиад явж байгаа. Яагаад аялал жуулчлалын энэ холбоодод гишүүнчлэлтэй гишүүн компаниудын нэрсийг өгсөн юм бэ гэхээр өөр салбарын хүмүүс аялал жуулчлалын салбарын нэрийг бариад зээл авчих вий энэ зөвхөн манай энэ салбарыг босгож ирэхэд зориулсан зээл юм шүү гэдэг утгаараа бид бүхий л энэ аялал жуулчлалын мэргэжлийн чиглэлийн холбоодынхоо гишүүдийнх нь нэрсийг өгсөн гэсэн үг. Би түрүүн нөгөө дутуу гишүүд гэдгийг нь хэлээгүй орхичихсон байна.

Тэгээд арилжааны банкнууд дээр Монголбанкнаас хяналт тавина. Энэ зээлийг гаргахын өмнө зээлийн үлгэрчилсэн гэрээ гэдэг зүйлийг боловсруулаад, Сангийн яаман дээр хянагдаад, Монголбанк хянагдаад ингээд 3 тал манай яамтай хамтраад гарын үсэг зураад, үргэлжлүүлээд арилжааны банкнууд гарын үсэг зураад энэнийхээ дагуу энэ зээл нь хэрэгжээд явна гэсэн үг. Үүнээс гадна манай яамны зүгээс яг зээл авахаар тухайн компани шалгарвал бид хариуцлагын гэрээ гуравласан гэрээнд манай яам гарын үсэг зурна. Тэгэхээр тэн дээр нь бид тодорхой хэмжээний цензур тавьж ажиллах боломжтой байх гэж бодож байна.

МСҮТ-ийн хувьд бид БНСУ-ын КОЙКА-гийн санхүүжилттэй маш том барилга бидэнд барьж Байгаль орчны яаманд хүлээлгэж өгсний барилга болон газрын гэрчилгээг манай яам руу энэ аялал жуулчлалын зориулалттай учраас шилжүүлж авах ажлыг өнгөрсөн хугацаанд хийсэн. Ингээд барилгаа бид МСҮТ-ийн зориулалтаар ашиглая гээд Боловсролын яаманд МСҮТ байгуулах хүсэлтээ өгчихсөн. Тэгээд энэ ЗГ-аар орж байгуулагдах ёстой. Тэгээд Мэргэжлийн боловсролын хуулийн дагуу мэргэжлийн холбоод нь энэ МСҮТ-ийнхээ удирдах зөвлөлийн 51 хувьд нь ордог юм. Тийм учраас яг энэ салбартаа ажиллаж байгаа хүмүүс маань ямар мэргэжилтэн бэлдэх юм, үйл ажиллагаа нь яаж явах юм, төсвийг нь яаж батлах юм гэдэг дээрээ давуу оролцоотой явна гэсэн үг. Тэгэхээр Аялал жуулчлалын тухай хуулиар манайх яг яам маань аялал жуулчлалын мэргэжлийн холбоотойгоо байнга хамтран ажиллаж байгаа. Тэгэхээр энэ холбооноос нэлээн оролцоотой ингэж хамтарч ажиллана. Тэгээд урт ба богино хугацааны сургалтууд

түрүүний танилцуулсан Зочломтгой Монгол гэдэг хөтөлбөрийн хүрээнд бид явуулна. Тэгээд богино хугацааны сургалтууд гэхэд энэ үйлчилгээний стандартыг сайжруулах, хоолны чанарыг дээшлүүлэх гэх мэтчилэн ийм сургалт.../минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Сайдын микрофоныг сунгая, үргэлжлүүлж хариулья.

Ч.Ундрам: Мөн guide-н сургалтуудыг бид бас явуулна гэж бодож байгаа. Тэгээд энэ аялал жуулчлалын guide гэдэг манай Монгол Улсын түүх соёлыг үнэн зөвөөр олноороо ирсэн хүмүүст тайлбарлах ийм маш чухал үүрэгтэй байдаг учраас бид цаашид guide-уудыг бүгдийг нь маш нарийн сургалтад оруулж, шалгалт авч сертификатжуулахгүй бол бидний түүх соёлыг санамсаргүйгээр ч юм уу, санаатайгаар ч юм уу буруугаар хүмүүст тайлбарлаж ойлгуулах нь урт хугацаандаа Монголын бодлогод сөргөөр нөлөөлөх магадлалтай гэж үзэж байгаа.

Хөвсгөл рүү бол Мөрөн рүү дотоодын болон гадаадын нислэгүүд хийгдэж байгаа. Тэгээд ерөнхийдөө бид ямар ч л байсан эхний ээлжид хойд бүсэд Хөвсгөлийн Мөрөн рүү олон улсын болон дотоодын нислэгүүдийг авдаг болбол ойр орчмынхоо аймгууд руу тэндээсээ илүү хурдан очиж жуулчлах боломжтой гэж үзэж байгаа. Гэхдээ яалт ч үгүй ирэх жилүүдийн төсвийг бид төлөвлөхдөө энэ баруун, зүүн, урд, хойд бүсэд байгаа нэг, нэг нисэх онгоцны буудлын стандартыг сайжруулах хэрэгтэй. Яг одоо өнөөдөр Хөвсгөлийн Мөрөнгийн нисэх онгоцны буудалд нислэг авъя гэхээр онгоцны буух, нисэх замын өргөн, урт нь стандарт олон улсын стандарт шаардлагыг хангахгүй, мөн нэлээдгүй сайжруулалт, хөрөнгө оруулалтуудыг хийх шаардлагатай. Мөн орон тоог нь нэмж, хүмүүсийг нь сургах шаардлагатай байдаг. Тэгэхээр энэ дээр дараа дараагийн хөрөнгө оруулалтууд дээр эрхэм гишүүд анхаарч өгвөл маш хэрэгтэй байна. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Энхцэцэг гишүүн нэмж тодруулья.

М.Энхцэцэг: Баярлалаа. Саяын зээлтэй холбоотой дээр дахиад жаахан тодруулья гэж бодож байна л даа. Тэгэхээр энэ нэг компанид өгөх зээлийнх нь дээд хязгаар дээр ямар нэгэн тийм хязгаарлалт байгаа юу? Хэдхэн цөөхөн том аялал жуулчлалын хэдэн компаниуд нь аваад л нөгөө зээл чинь санхүүжилт чинь дуусчих ийм асуудал гарах эрсдэл байгаа юу? Дээрээс нь энэ зээлийн эцсийн зорилго чинь ерөнхийдөө мэдээж нөгөө санхүүжилт дутмаг байгаа, энэ аялал жуулчлалын салбарт нэг бизнес эрхэлчих гээд байгаа ийм хүмүүсээ л дэмжих зорилготой байх л даа энэ зээлийн зорилго чинь. Тэгэхээр энэ зорилгоо хангахын тулд шаардлага дээр нь жаахан илүү нарийвчилж өгөх ёстой байсан юм биш үү? Ерөнхийдөө энэ компаниудыг шалгаруулахдаа л нэлээн анхаарахгүй бол энэ жоохон асуудал үүсчих магадлалтай л юм шиг харагдаад байна л даа.

2 дугаарт нь яг энэ зээлийг юунд зарцуулах ёстой гэдэг бас нэг ийм шаардлага байгаа юу, одоо юу гэдэг юм жуулчны бааз байгуул, эсвэл.../минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Энхцэцэг гишүүний микрофоныг сунгая.

М.Энхцэцэг: Эсвэл тэр компанийнхаа хүмүүсийг сургахад зарцуул ч гэдэг юм уу, яг нөгөө тэр зээлийг юунд зарцуулах ёстой шүү, тэрний үр дүнд чинь би танай компаниас ийм л юмыг хүсэж байна манай Аялал жуулчлалын яам гэдэг ийм юм байхгүй юу. Мэдээж энэ зээл зарцуулагдлаа, та бүхэн ямар нэгэн юмыг зориод л энэ зээлийг ингээд гаргаж байгаа шүү дээ. Гэтэл энэ зээл ингээд зарцуулагдаад

дууссаны дараа та бүхэн зорилгодоо хүрсэн байх ёстой шүү дээ. Тэгэхээр энэ талаар л жоохон тодруулж хэлээч гэж хэлмээр байна. Тэгээд байгууллагууд ер нь хэд, та бүхэн нэр хүргэсэн байна. Гэтэл хөдөө орон нутгаар явахаар би ингээд аялал жуулчлалын юм эрхэлдэг юм энэ зээлийг ингээд авмаар байна гэсэн компаниуд маш их байдаг юм байна лээ, төрийн бус бүртгэгдээгүй компаниуд, жижиг компаниуд их байна гэсэн үг шүү дээ. Тэгээд тэд нарыг яаж хамруулах юм бэ гэдэг асуудал.

Н.Батсүмбэрэл: Ундрам сайдын микрофоныг нээе.

Ч.Ундрам: Энэ зээлийн хувьд энэ жилийн хувьд батлагдсан төсвийнхөө хүрээнд бид 250 орчим тэрбум төгрөг энэ салбар луу зээл болгож олгох боломж байгаа. Тэгээд 1 зочид буудал бол 7 тэрбум хүртэлх зээл авч болно. Энд нь 1 ч байж болно, 2 ч юм уу, 3 ч юм уу 7 хүртэл, жуулчны бааз бол 2 хүртэл тэрбум, тэгээд зам дагуух үйлчилгээний газрууд ариун цэврийн байгууламжтай, нутгийн иргэдийн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах цэгтэй, хоолны газар, кофе шоптой ийм газрууд бол 3 хүртэлх тэрбум төгрөгийн зээл авах боломжтой. Тэгэхээр энэ маань бас нэлээн ингээд тархаж хүрэх боломжтой гэж үзэж байгаа. Бидний хувьд түрүүн баталсан зочид буудал, зоогийн газрын зэрэглэлийн журмыг баталсан. Тэгэхээр энэ газруудаа аль болохоор үйлчилгээний өндөр стандарттай ийм хөрөнгө.../минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Лувсанжамц гишүүний микрофоныг нээе.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. Аялал жуулчлалын яамны үйл ажиллагаа, гаргаж байгаа үр дүнд сэтгэл хангалуун байгаа. Нэг асуулт байна. Ихэнх авиа компаниуд үнээ 4 сарын 1-нээс нэмээд эхэлж байгаа. Бид эхний 2 сарын байдлаар жуулчны тоо 33 хувийн өсөлттэй байна. Цаашдаа дахиад түлшний үнэ нэмэгдээд явна. Энэ жил та хэд маань өнгөрсөн жилтэй харьцуулахад хэдий хэмжээний жуулчин ихсэх ч байдаг юм уу, багасах ч байдаг юм уу тийм төсөөлөл судалгаа байгаа болов уу нэгдүгээрх нь?

Хоёрдугаарх нь хүсэлт байна. Нийт жуулчдын тоо байна, экспортын орлого, салбарын нийт эдийн засаг гээд харж байгаа энийг улсаар нь ангилж хармаар байгаа. Аль улсаас, хэдий хэмжээний жуулчид ихсэж ирж байгаа, тэгээд мэдээж манай мэргэжлийн холбоод маань байгаа учраас аль бүс рүү, аль улсын жуулчид явж байгаа ийм зүйлүүдийг бас харвал зүгээр болов уу гэж бодож байна. Тэгээд дотоодын аялал жуулчлалын тайлан 2025 оны судалгааны тайлан бас байсан. Тэндээс харахад бид өөрсдөө хангайн бүс рүүгээ явчихдаг. Тэгэхлээр гаднын жуулчид хаашаа явж байгаа, тэгээд энэнээсээ хамаараад та бүхний маань хэрэгжүүлэх бодлого, стратеги нь өөр байх болов уу гэж бодож байгаа. Тэгэхлээр тийм зүйл дээр жоохон нарийвчилсан судалгаанууд байвал тийм мэдээлэл өнөөдөр биш байж болж болно л доо, дараа нь бас явуулж өгвөл хэрэгтэй байна гэсэн 2 санал байна.

Н.Батсүмбэрэл: Ундрам сайдын микрофоныг нээе.

Ч.Ундрам: Бид яг өнөөгийн энэ геополитикийн нөхцөл байдал, Ойрх Дорнодын энэ шатахуунтай холбоотой үнийн өсөлтөөс өмнө энэ жил 1 сая орчим жуулчин хүлээж авах юм байна гээд мэргэжлийн байгууллагуудтайгаа хамтраад тооцоо судалгаа гаргасан. Гэвч ирэх сараас эхлээд авиа компаниудын үнэ нэмэгдэж байгаа. Манай орны хувьд хамгийн олон жуулчин БНХАУ, ОХУ-аас тооны хувьд ирдэг. Ирээд бид бол нөгөө чанартай жуулчин авахыг илүү зорьж байгаа. Ирээд их

хэмжээний худалдан авалт хийдэг. Тэрүүгээр нь жагсааж үзвэл 1 дүгээрт Австрали, Шинэ Зеландаас ирсэн жуулчид, 2 дугаарт жижиг орнууд гэж байгаа юм, 3 дугаарт БНХАУ гээд, үүний араас нэлээн барууны орнууд, мөн Япон улс, 9-д БНСУ, 10-т ОХУ гээд. Ерөнхийдөө жуулчдаа хэн нь ирээд, дунджаар хэд хоноод, хэдэн төгрөг зарцуулдаг вэ гэдгийг нь гаргачихсан байгаа. Тэгээд аль болохоор чанартай жуулчныг татахын тулд бид барууны улс орнууд, БНХАУ, Япон улсын жуулчдыг татах нь хамгийн чухал гэж үзэж байгаа.

Тэгээд мэдээж энэ жуулчдыг татаад гол нь нөгөө мөнгөө зарцуулах зүйлсийг нь бид бэлдэх ёстой. Энд худалдан авахад наад зах нь бараа, бүтээгдэхүүнүүд, ноос ноолууран бүтээгдэхүүнүүд өнөөдөр хамгийн их жуулчид худалдаж авдаг бол үүн дээрээс нэмээд өөр ямар зүйлүүдийг ирэхэд нь бид борлуулж болох вэ, юу үзүүлж болох вэ гэдэг аль болохоор их хэмжээний худалдан авалт хийхийг нь л дэмжих ийм бодлогыг баримталж ажиллаж байгаа. Тэгээд энэ жил анх удаа Үндэсний статистикийн хороотой хамтраад аялал жуулчлалын салбарын тоо статистикийг илүү боловсронгуй болгох ажлын хэсэг байгуулаад бид ийм статистик тайлан мэдээллийг гаргасан байгаа. Тэгээд цаашид энийгээ улам боловсронгуй болгоод яг аль улсын жуулчин нь яг аль хэсгийг илүү сонирхоод байна вэ гэдгийг тодорхойлж segment-тэлж гаргаад, тийшээгээ чиглэсэн ажлуудыг хийх ёстой.

Гэхдээ сүүлийн үед гарсан олон улсын судалгаануудаас бол жуулчид манай соёлыг илүү сонирхдог. Тэгээд соёл дотроо жишээлбэл spiritual буюу шашны аялал жуулчлал, зарим нь бөө мөргөлийг бас сонирхож байна, зарим нь иог бөгөөд эрүүл мэндийн жуулчлал их сонирхолтой сегмент болж байна. Жишээлбэл хүүхдээ аутизмаас нь ч юм уу, эсвэл өөрсдөө depress мэдрэлийн ядаргаанаасаа гарахын тулд ийм онгон дагшин байгальд гарч ан амьтантай, эсвэл морьтой ч юм уу харьцах ингэснээр стресс тайлагдах гэх мэтчилэн ийм зөвхөн магадгүй Монгол Улсад л үзэж болохоор ийм бүтээгдэхүүнүүд гарч байна. Үүнээс.../минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Микрофон сунгая.

Ч.Ундрам: Одоо бид энэ 1 саяыг бид нөхье гэж бодож байгаа. Тэр нь юу вэ гэхээр БНХАУ-тай хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх ийм 2 улсын хэлэлцээрийг хийгээд, 2 улсын ЗГ зөвшөөрчихсөн юм. Тэгээд манай яамнаас энэ хил орчмын аялал жуулчлалыг яг хэдэн хүний группээр орж ирээд, говийн бүс нутгаар хэд хоноод, яг ямар радиус нь байгаад буцаж гарах юм бэ гэдэг журмын төслийг боловсруулаад, Хууль зүйн яаманд хэд хэдэн удаа хүргээд, тэндээс хамтарч батлах ёстой боловч ерөөсөө баталж өгөхгүй, тодорхой бас мэдээж үндэсний аюулгүй байдал олон зүйлээ л харж байгаа байх. Тийм учраас ингээд жоохон хүлээгдээд, засварууд хийгдээд ингээд яваад байгаа. Хэрвээ тэр батлагдчихвал заавал авиа компаниар гэхгүй, яг манай хилийг дагаад маш олон сая хүмүүс 100 сая хүмүүс амьдарч байгаа учраас хил орчмын аялал жуулчлалыг бид хөгжүүлбэл энэ алдагдаж байгаа тоогоо нөхөх боломжтой гэж үзээд ажиллаж байгаа. Тийм.

Мөн цайны замын аялал жуулчлалыг бид хөгжүүлэх гээд 3 улсын аялал жуулчлалын сайд нарын уулзалтыг цайны зам дагуу Дархан хотод зохион байгуулсан. Тэгээд энд бол авто ралли аялал, тэгээд автомашинаасаа буугаад дунд нь тэмээн жингээр нэг хэсэг явдаг ч юм уу, морин аяллаар явдаг гээд яг ийм цайны замын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлээд хөрш 2 улстайгаа хамтарч ажиллаж байгаа. Тийм.

Н.Батсүмбэрэл: Баярлалаа. Би 3 юм асуучихъя. 1 дүгээрт энэ хууль, эрх зүйн хувьд шинэчлэл хийгдсэн 2023 онд хийгдсэн байна. Тэгээд энэ хууль, эрх зүйн хувьд шинэчлэх, өөрчлөлт оруулах шаардлага байгаа юу? Энэ дээр Их Хурлын гишүүдээс анхаарч ажиллахаар асуудлууд юу байна вэ? Их Хурлын тогтоолоор ч юм уу, аялал жуулчлалын салбар дээр хэрэгтэй байгаа эрх зүйн зохицуулалт хэр байна вэ гэсэн нэг асуулт. Бэрхшээл байгаа бол түүнийг яаж шийдэх вэ.

2 дахь асуудал нь 2027 оны төсөв одоо ингээд удахгүй эхлэх нь байна. Өнөөдрөөр сум, дүүргүүд мэдээллээ өгч, дуусаж байгаа. Ирэх сар, одоо сарын дараа аймаг, нийслэлүүд нэгтгэнэ. Тэгэхлээр 2027 оны улсын төсөв дээр ямар боломж тооцооллууд хийж байна, хөрөнгө оруулалтаа яаж нэмэгдүүлэх гэж байна гэсэн ийм 2 дахь асуулт.

3 дахь нь дэлхий дахины геополитикийн нөхцөл, дайнаас хамааралтайгаар эдийн засгийн хүндрэл бодитой бий болох нь энэ шатахууны өртгөөс болоод. Үүнийг дагасан хүндрэл бий болно. Энэ хүндрэлийг та бүхэн яаж харж байна вэ? Үүнд зориулсан аялал жуулчлалын салбарын хариу арга хэмжээний төлөвлөгөө та нар хийж байна уу? Ийм асуулт. Ундрам сайдын микрофон өгье.

Ч.Ундрам: Яг одоогийн байдлаар бид Аялал жуулчлалын хууль маань батлагдаад 5 жил болоогүй, 5 жилийн дараа үнэлгээ хийгдэнэ гэж бодож байгаа. Энэ хууль маань маш сайн том хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн гэж бодож байгаа. Улсын Их Хурлын гишүүдээсээ хүсэх зүйл 1 дүгээрт бид энэ зээлийг үргэлжлүүлмээр байгаа ирэх жил. Тийм учраас зээлийн татаасыг нэмэх хүсэлт байгаа. Одоогоор бид 250 орчим тэрбум төгрөг л зээлд гаргах боломж байгаа боловч салбараас ирсэн хүсэлт нь 700, 800 тэрбумын хүсэлт банкнууд дээр ирчхээд байгаа. Тэгэхдээ мэдээж банкны шүүлтүүрээр орно. Ирэх жил бид хэрвээ энэ салбарыг дэмжээд, эдийн засгаа солонгоруулъя гэвэл нэг их наяд төгрөгийн зээл гаргах боломжийг бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа.

2 дугаарт нисэх буудал бол ерөөсөө аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамгийн чухал байдаг учраас Хөвсгөл аймгийн, Хөвсгөл аймаг, Өмнөговь аймаг, мөн Дорнод, Ховд аймгуудын нисэх буудлыг олон улсын нислэг хүлээж авах ийм боломжтой болгох хөрөнгө оруулалт бидэнд зайлшгүй шаардлагатай гэж бодож байгаа. Тэгээд мөн жуулчдын визийг бид Гадаад хэргийн яам, Хууль зүйн яамтайгаа хамтраад олон улсын визийг чөлөөлж өгсөн. Гэхдээ энэ ганцхан жилээр чөлөөлөгдөөд байдаг. Гэтэл хүмүүс чинь бүр жилийн өмнө хаашаа явахаа төлөвлөчихдөг, 2 жилийн өмнөөс ч юм уу бараг төлөвлөчихдөг улс орнууд байдаг болохоор энэ улс орнуудын визийг нэг мөр чөлөөлбөл 3 жил ч юм уу, 3-аас 5 жил чөлөөлчихдөг. Дээрээс нь энэ визээс нь чөлөөлөхөөр нөгөө гаднын жуулчны хүмүүс жуулчид маань орж ирээд tourist гэдэг ангиллыг л бөөрөнхийлөхгүй бол өөр ангиллыг санамсаргүй бөглөчихдөг. Тэгэнгүүт хил дээр бас ийм асуудал гардаг. Тэгэхээр энэ дээр бид ингээд илүү гаалийнхан хилийнхэн маань нэлээн уян хатан энийг ойлгож, ингэж зочломтгой байдлаар хүлээж аваасай гэж бодож байгаа.

Мөн хил орчмын аялал жуулчлалыг бид цаашид хэрэгжүүлэхийн тулд Хууль зүйн яамны хамтын ажиллагаа маш их чухал байгаа. Тэгээд тэнд нэлээн ийм хатуу ийм ойлголтууд, бодлогууд яваад байдаг болохоор энийг бид тайлбарлахад чадлаараа тайлбарлаж байгаа. Тэгэхдээ Их Хурлын гишүүдийн зүгээс бас тийшээгээ асуулга тавиад, мөн ийм Аялал жуулчлалын дэд хороотой болсонд маш их баяртай байгаа. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань хил орчмын аялал жуулчлалтай холбоотой Хууль зүйн яамыг дуудаж асуух, мөн Зам, тээврийн яамыг

дуудаж асуух гээд бидний уялдаа холбоог хангуулж ажиллуулахад дэмжлэг болж өгөөч гэж хүсмээр байна.

Н.Батсүмбэрэл: Дэд хорооны хуралдаан дуусаж байна. Хуралдаанд оролцож, үг хэлсэн гишүүд, асуултад хариулсан, мэдээлэл өгсөн яамны сайд, газрын дарга нарт талархал илэрхийлье.

Дэд хорооны ажлын албанаас саяын яриад байгаа асуудлуудаар Хууль зүйн яам, гаалийн байгууллагуудаас мэдээлэл албан бичгээр тодруулж авъя. Энийг Билэг-Өрнөх анхааръя. Тэгээд хүсэлт ирүүлсний дагуу урьдчилсан байдлаар мэдээлэл ирчихсэн байж байгаа. Ирэх долоо хоногт дэд хорооны хурлыг дахиж хуваарьт оруулахаар санал болгоё. Тэгээд тэн дээр Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны байгууллагын мэдээллийг авч, энэ дээр гишүүд, өнөөдөр бол бид төрийн байгууллагын мэдээллийг сонслоо. Дараагийн удаа бол аялал жуулчлалын салбарын мэргэжлийн байгууллагын төрийн бус байгууллагын мэдээлэл сонсож авъя гэсэн ийм саналтай байна.

16.46 цаг

Өнөөдрийн хуралдаан хааж байна. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА